

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэлд:

“ХИҮ.2. Засгийн газрын гишүүдийн 2013 оны гадаад айлчлалын хуваарийн тухай Гадаад харилцааны сайд Л.Болд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

2.1. Засгийн газрын гишүүдийн 2013 оны гадаад айлчлалын хуваарийг зүйтэй гэж үзэв (Хавсралт);

2.2. Тухайн айлчлалын удирдамжийг Гадаад харилцааны сайдын саналыг үндэслэн боловсруулж Ерөнхий сайдаар батлуулж, айлчлалын дүнг 7 хоногийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав;

2.3. Засгийн газрын гишүүд ОХУ, БНХАУ-ын холбогдох яам, байгууллагын урилга болон ажлын шаардлагаар ОХУ, БНХАУ-д айлчлах асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДИЙН 2013 ОНЫ ГАДААД
АЙЛЧЛАЛЫН ХУВААРЬ

№	Сайд	Хоёр талын айлчлал	Олон улсын хурал, ЗГХК
1.	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга	АНУ, ИБУИНВУ	vxAD0064
2.	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	Австрали Улс, Израиль Улс	Даян дэлхийн Байгаль орчны сайд нарын 31 дүгээр чуулга уулзалт (Кени), ЗГХК (Унгар), Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаархи НҮБ-ын бага хурал
3.	Сангийн сайд	АНУ, Бүгд Найрамдах Энэтхэг Улс	Дэлхийн банк, ОУВС-гийн жилийн болон хаврын уулзалт (АНУ), Азийн хөгжлийн банкны захирагчдын зөвлөлийн уулзалт (Энэтхэг), ЕСБХБ-ны захирагчдын зөвлөлийн уулзалт (Түрк)
4.	Хууль зүйн сайд	ХБНГУ, Канад Улс	
5.	Барилга, хот байгуулалтын сайд	ХБНГУ, Япон Улс	ЗГХК (Чех)
6.	Батлан хамгаалахын сайд	Бүгд НайрамдахТүрк Улс, Украин Улс	“Шангри-Ла” Азийн аюулгүй байдлын бага хурал (Сингапур), НАТО-гийн гишүүн болон түнш орнуудын Батлан хамгаалахын сайд нарын уулзалт (Бельги)
7.	Боловсрол, шинжлэх ухааны сайд	ИБУИНВУ, Бүгд Найрамдах Сингапур Улс	ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын ээлжит чуулган (Франц), ЗГХК (Энэтхэг)
8.	Зам, тээврийн сайд	Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон Улс	Дэлхийн зам, тээврийн форум (Герман)
9.	Соёл, спорт, аялал жуулчлалын сайд	АНУ, Бүгд Найрамдах Франц Улс	Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Ерөнхий Ассамблейн 20 дугаар чуулган (Зимбабве)
10.	Уул уурхайн сайд	Австрали Улс, Япон Улс	Дэлхийн эдийн засгийн 2013 оны чуулга уулзалт (Швейцар), Уул уурхайн чуулга уулзалт-PDAC 2013 (Канад)
11.	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	ХБНГУ, Бүгд Найрамдах Солонгос Улс	Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Бага хурлын 38 дугаар чуулган (Итали), ЗГХК (Вьетнам)
12.	Хөдөлмөрийн сайд	ХБНГУ, Бүгд Найрамдах Солонгос Улс	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий бага хурлын 102 дугаар чуулган (Швейцар)
13.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	Канад Улс	Нийгмийн хөгжлийн комиссын 51 дүгээр чуулган (АНУ)
14.	Эрчим хүчний сайд	Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс	ОУСЭХА-ийн гуравдугаар чуулган, “Дэлхийн эрчим хүчний ирээдүй” Ү1 чуулга уулзалт, Усны анхдугаар чуулга уулзалт (АНЭУ)
15.	Эрүүл мэндийн сайд	Бүгд Найрамдах Австри Улс, ИБУИНВУ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 66 дугаар чуулган (Швейцар), Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэх зөвлөлийн хуралдаан (Швейцар)